



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
УЛААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 1/38

Төгөл

**Согтууруулах ундаа худалдан
борлуулахыг хязгаарлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус суманд архидан согтууралт ойрын өдрүүдэд их байгаа тул цагдаагийн хэсгээс "Архигүй 7 хоног" хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж байна. Иймд архи согтууруулах ундаа худалдаалдаг тусгай зөвшөөрөл бүхий цэгүүдийг 2024 оны 04 дугаар сарын 5-ний өдрөөс 2024 оны 04 дугаар сарын 14-ний өдөр хүртэл хязгаарласугай.

2. Зориулалтын бус газарт болон нууцаар архи согтууруулах ундаа худалдан борлуулах мөн тээвэрлэсэн этгээдэд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг сумын хэсгийн төлөөлөгч (Б.Батзаяа)-д үүрэг болгосугай.

3. Хязгаарласан хугацаанд архи согтууруулах ундааг битүүмжлэн хяналт тавьж ажиллахыг хэсгийн төлөөлөгч (Б.Батзаяа)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (М.Батцогт)-г даалгасугай.

ДАРГА  Н.БАТБАЯР

